



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Г Сургалт зохион байгуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6, тус газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэд жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдээлэл туслалцаа үзүүлэх, хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэх зорилгоор Улаанбаатар хотын Цагдаагийн газрын эргүүлийн цагдаа, офицер, оюутан цагдаа нарт зориулсан мэргэжлийн англи хэл, харилцааны сургалтыг 2016 оны 04-06 дугаар сард зохион байгуулсугай.

2. Сургалтуудыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.

4. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 03 сарын  
21-ний өдрийн 17200от тушаалын  
хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРГҮҮЛИЙН ЦАГДАА,  
ОФИЦЕР, ОЮУТАН ЦАГДАА НАРТ ЗОРИУЛСАН МЭРГЭЖЛИЙН АНГЛИ ХЭЛ,  
ХАРИЛЦААНЫ СУРГАЛТЫН ТӨСӨВ

1. Улаанбаатар хотын Цагдаагийн газрын эргүүлийн цагдаа, офицеруудын  
сургалтын төсөв

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ /акад/цаг/	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Нэгдүгээр ээлжийн сургалт /40 цагдаа/	60 акад/цаг	25.000	1.500.000
2	Хоёрдугаар ээлжийн сургалт /35 цагдаа/	60 акад/цаг	25.000	1.500.000
	<b>Нийт</b>			<b>3.000.000</b>

2. Оюутан цагдаа нарын сургалтын төсөв

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ /акад/цаг/	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Нэгдүгээр ээлжийн сургалт /50 оюутан/	30 акад/цаг	16.666.6	500.000
2	Хоёрдугаар ээлжийн сургалт /50 оюутан/	30 акад/цаг	16.666.6	500.000
	<b>Нийт</b>			<b>1.000.000</b>